

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/42/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn Шонхор үнэлгээ аудит .ХХК-ийн захирал: Д.Шийрэв Утас: 88880963 Цахим хаяг: Shonkhor.mn@gmail.com
-----------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.УЛАМБАЯР ТАНАА

2024.02.29 № 07/522
төний _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/38 дугаар тушаалаар "Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", А/41 дүгээр тушаалаар "Алтанбулаг чөлөөт бүсийн стратеги төлөвлөгөө", А/44 дугаар тушаалаар "Алтанбулаг чөлөөт бүсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус баталсан байна.

Аудитын гол асуудал

Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2022.02.16-ны өдрийн 01/77 дугаартай албан бичгээр "Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх цогц ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа тул чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөл олгохгүй байхыг үүгээр мэдэгдэж байна" гэсэн мэдэгдэл ирүүлсний дагуу одоог хүртэл "Алтанбулаг" чөлөөт бүсэд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинээр газар олголт хийгдээгүйн улмаас орлого төвлөрүүлэх үйл ажиллагаа тасалдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 57 арга хэмжээний гүйцэтгэл ЗГХЭГ-ийн даргын 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтад тусгагдсанаар 98.4 хувьтай үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>269,889,940.41</u>	<u>275,987,809.49</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,200,058.00	72,200,058.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	72,200,058.00	72,200,058.00
3121	Төгрөг	72,200,058.00	72,200,058.00
31211	Төрийн сангийн харилцах	72,200,058.00	72,200,058.00
33	АВЛАГА	191,316,221.12	192,269,548.00
335	Бусад авлага	191,316,221.12	192,269,548.00
3351	Байгууллагаас авах авлага	191,316,221.12	192,269,548.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,373,661.29	11,518,203.49
354	Хангамжийн материал	6,373,661.29	11,518,203.49
35410	Бичиг хэргийн материал	345,256.80	3,658,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	148,500.00	148,500.00
35470	Бусад хангамжийн материал	5,879,904.49	7,710,903.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,218,093,237.91</u>	<u>19,354,674,832.06</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,218,093,237.91	19,354,674,832.06
392	Биет хөрөнгө	15,049,827,037.91	14,186,983,632.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,144,924,971.64	19,144,924,971.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,262,934,367.40)	(5,121,679,566.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,750,000.00	5,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,750,000.00)	(5,750,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	358,598,320.50	330,286,814.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(297,604,920.78)	(273,226,454.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,629,116.68	77,438,672.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,000,549.73)	(62,975,272.33)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	92,214,467.00	92,214,467.00
393	Биет бус хөрөнгө	5,168,266,200.00	5,167,691,200.00
39301	Програм хангамж	3,700,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,125,000.00)	(3,700,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,422,966,200.00	5,422,966,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(255,275,000.00)	(255,275,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>20,487,983,178.32</u>	<u>19,630,662,641.55</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>89,473,590.83</u>	<u>106,516,578.24</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,473,590.83	106,516,578.24
413	Өглөг	89,473,590.83	106,516,578.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,016,932.83	00.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	72,200,058.00	72,200,058.00
4136	Бусад өглөг	5,256,600.00	34,316,520.24
41361	Байгууллагад төлөх өглөг	5,256,600.00	34,316,520.24

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>20,398,509,587.49</u>	<u>19,524,146,063.31</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	20,398,509,587.49	19,524,146,063.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,542,753,318.00	6,542,753,318.00
51101	Өмч: - төрийн	6,542,753,318.00	6,542,753,318.00
512	Хуримтлагдсан үр дүн	13,542,934,655.41	12,668,571,131.23
51210	Өмнөх үеийн үр дүн	13,542,934,655.41	13,542,934,655.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(874,363,524.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	312,821,614.08	312,821,614.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>20,487,983,178.32</u>	<u>19,630,662,641.55</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	763,463,319.00	1,036,781,251.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,117,519.00	102,561,484.27
120	Нийтлэг татварын бус орлого	79,117,519.00	102,561,484.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,117,519.00	102,561,484.27
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,117,519.00	95,113,148.88
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,448,335.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	684,345,800.00	934,219,766.76
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	684,345,800.00	934,219,766.76
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	684,345,800.00	934,219,766.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,882,258,662.63	1,911,144,775.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,882,258,662.63	1,911,144,775.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,736,394,078.47	1,871,540,624.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	531,693,144.86	740,389,769.79
210101	Үндсэн цалин	367,036,088.94	519,216,301.19
210102	Нэмэгдэл	79,239,019.00	102,308,923.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,681,499.92	77,421,189.12
210104	Урамшуулал	34,736,537.00	41,443,356.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,965,922.10	37,328,721.27
210201	Тэтгэврийн даатгал	41,857,339.55	25,003,749.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,359,974.43	2,797,871.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,901,762.81	2,183,378.63
210204	Ажилгүйдлийн даатгал	895,167.88	653,331.71
210205	Эрүүл мэндийн даатгал	8,951,677.43	6,690,389.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,111,160.00	60,036,113.40
210301	Гэрэл, цахилгаан	21,913,740.00	22,282,337.79
210302	Түлш, халаалт	31,012,720.00	31,012,042.61
210303	Цэвэр, бохир ус	2,958,900.00	2,850,873.00
210304	Байрны түрээс	5,225,800.00	3,890,860.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,809,181.71	4,318,664.80
210401	Бичиг хэрэг	1,429,425.00	1,971,506.80
210402	Тээвэр, шатахуун	1,166,300.00	852,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,213,456.71	1,494,458.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,272,680.00	17,422,101.00
210604	Урсгал засвар	1,272,680.00	17,422,101.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,616,607.00	133,908,912.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,426,840.00	128,450,618.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	1,960,000.00

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	2,040,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,857.00	187,014.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,571,000.00	605,080.65
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,353,900.00	666,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,050,925,382.80	878,136,341.24
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,050,599,882.80	870,866,741.24
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	7,269,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,864,584.16	39,604,151.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	650,000.00	21,400,890.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,420,690.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	980,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	145,214,584.16	18,203,261.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,214,584.16	18,203,261.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,118,795,343.63)	(874,363,524.18)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,118,795,343.63)	(874,363,524.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	818,965,322.00	1,044,610,561.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,619,522.00	85,793,771.00
120	Нийтлэг татварын бус орлого	134,619,522.00	85,793,771.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	134,619,522.00	85,793,771.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	134,619,522.00	85,793,771.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	684,345,800.00	958,816,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	684,345,800.00	958,816,790.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	684,345,800.00	958,816,790.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	818,965,322.00	1,044,610,561.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,965,322.00	1,044,610,561.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	673,100,737.84	1,005,006,409.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,984,716.34	706,723,599.69
210101	Үндсэн цалин	357,586,629.80	448,467,330.21
210102	Нэмэгдэл	78,470,549.28	121,237,655.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,385,313.51	83,033,797.68
210104	Урамшуулал	34,542,223.75	53,984,816.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,657,417.79	83,011,824.20
210201	Тэтгэврийн даатгал	41,227,145.05	57,172,188.21
210202	Тэтгэмжийн даатгал	4,839,355.16	6,645,104.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,841,244.05	5,246,722.77
210204	Ажилгүйдлийн даатгал	813,592.18	1,251,504.49
210205	Эрүүл мэндийн даатгал	8,936,081.35	12,696,304.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,050,600.00	58,267,862.40
210301	Гэрэл, цахилгаан	39,954,200.00	50,124,005.40
210302	Түлш, халаалт	5,137,500.00	5,270,159.00
210303	Цэвэр, бохир ус	2,958,900.00	2,873,698.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,557,956.71	5,007,288.65
210401	Бичиг хэрэг	598,900.00	2,292,650.00
210402	Тээвэр, шатахуун	965,600.00	1,260,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,456.71	1,454,538.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,272,680.00	19,793,100.00
210604	Урсгал засвар	1,272,680.00	19,793,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,161,867.00	131,999,135.00

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,788,100.00	128,461,321.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	1,960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,857.00	196,614.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,719,500.00	715,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,359,400.00	666,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	415,500.00	203,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	415,500.00	203,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,864,584.16	39,604,151.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	650,000.00	21,400,890.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,420,690.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	980,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	145,214,584.16	18,203,261.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,214,584.16	18,203,261.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72,200,058.00	72,200,058.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,200,058.00	72,200,058.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	14,661,729,999.04	21,517,304,931.12
Тайлант үеийн үр дүн	-	-	(118,795,343.63)	(118,795,343.63)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	13,542,934,655.41	20,398,509,587.49
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	13,542,934,655.41	20,398,509,587.49
Тайлант үеийн үр дүн	-	-	(874,363,524.18)	(874,363,524.18)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	12,668,571,131.23	19,524,146,063.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,501,581,814.1	1,044,610,599.94	3,456,971,214.1	23.21
УРСГАЛ ЗАРДАЛ	1,307,809,514.08	1,026,407,299.94	281,402,214.1	79.87
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,230,929,914.08	1,005,006,409.94	225,923,504.1	81.65
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	881,270,714.08	706,723,599.69	174,547,114.4	80.19
Үндсэн цалин	517,293,800.00	448,467,330.21	68,826,469.8	86.69
Нэмэгдэл	226,958,300.00	121,237,655.40	105,720,644.6	53.42
Унаа хоолны Хенгелелт	83,033,797.68	83,033,797.68	-	100
Урамшуулал	53,984,816.40	53,984,816.40	-	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,198,400.00	83,011,824.20	47,186,575.8	63.76
Тэтгэврийн даатгал	94,287,500.00	57,172,188.21	37,115,311.8	60.64
Тэтгэмжийн даатгал	9,637,100.00	6,645,104.05	2,991,996.0	68.95
ҮОМШ-ний даатгал	7,035,600.00	5,246,722.77	1,788,877.2	74.57
Ажилгүйдлийн даатгал	1,749,000.00	1,251,504.49	497,495.5	71.56
Эрүүл мэндийн даатгал	17,489,200.00	12,696,304.68	4,792,895.3	72.60
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,664,900.00	58,267,862.40	3,397,037.6	94.49
Гэрэл, цахилгаан	50,128,800.00	50,124,005.40	4,794.6	99.99
Түлш, халаалт	8,635,800.00	5,270,159.00	3,365,641.0	61.03
Цэвэр, бохир ус	2,900,300.00	2,873,698.00	26,602.0	99.08
Хангамж, бараа материалын зардал	5,165,000.00	5,007,288.65	157,711.4	96.95
Бичиг хэрэг	2,293,500.00	2,292,650.00	850.0	99.96
Тээвэр, шатахуун	1,260,100.00	1,260,100.00	-	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,611,400.00	1,454,538.65	156,861.4	90.27
Эд хогшил, урсгал засварын зардал	19,793,100.00	19,793,100.00	-	100
Урсгал засвар	19,793,100.00	19,793,100.00	-	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,634,200.00	131,999,135.00	635,065.0	99.52
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	128,777,100.00	128,461,321.00	315,779.0	99.75
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,960,400.00	1,960,000.00	400.0	99.98
Даатгалын үйлчилгээ	146,800.00		146,800.0	-
Тээврийн хэрэгслийн татвар	221,800.00	196,614.00	25,186.0	88.64
Тээврийн хэрэгслийн оношлогоо	13,400.00		13,400.0	-
Мэдээллийн технологийн үйлчилгээ	848,500.00	715,000.00	133,500.0	84.27
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	666,200.00	666,200.00	-	100
Бараа үйлчилгээний бусад зардал	203,600.00	203,600.00	-	100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	203,600.00	203,600.00	-	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,879,600.00	39,604,190.00	37,275,410.0	
Төсвийн урсгал шилжүүлэг		18,203,300.00	(18,203,300.0)	27.84

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн менген тэтгэмж	75,899,400.00	20,420,690.00	55,478,710.0	26.90
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,200.00	980,200.00		100
ХӨРСНГИЙН ЗАРДАЛ	3,193,772,300.00	-	-	-
Барилга байгууламж	3,193,772,300.00	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,501,581,814.08	1,044,610,561.00	3,456,971,253.1	23.21
Улсын төсвөөс санхүүжих	4,269,517,314.08	958,816,790.00	3,310,700,524.0	22.46
Улсын төсвөөс санхүүжих	4,269,517,314.08	958,816,790.00	3,310,700,524.0	22.46
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	232,064,500.00	85,793,771.00	146,270,729.0	36.97
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	232,064,500.00	85,793,771.00	146,270,729.0	36.97
АЖИЛЛАГСДЫН ТОО	42	42		100
Удирдах ажилтан	2	2		100
Гүйцэтгэх ажилтан	28	28		100
Үйлчлэх ажилтан	12	12		100
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	42		100
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	33	33		100
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	9	9		100
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	2		100
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	2		100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24.5 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь 1 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 19.0 хувиар олгох байсныг 38.0 хувиар тооцсоноос 198.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	198.6	1	198.6								
Тайлант онд 232,064.5 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр батлагдсанаас 85,793.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 63.0 хувиар дутуу биелүүлснээс шалтгаалан 24,318.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүссэн байна.	1	24,318.9			1	24,318.9						
Дүн	2	24,517.5	1	198.6	1	24,318.9						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 152.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Чөлөөт бүсэд газар эзэмших эрхтэй байгууллагуудаас авах 2010-2021 оны хооронд үүссэн 152,062.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдвэрлүүлэхээр шилжсэн авлагуудыг шийдвэрлүүлэх талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.	1	152,062.5			1	152,062.5				
Дүн	1	152,062.5			1	152,062.5				